

Хэрэглэгчийн ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

3.

Төрийн алба, үйлчилгээний гүйцэтгэлийн талаар иргэдээс авах үнэлгээний санал асуулгыг 3 өөр хувилбараар зохион байгуулж авсан.

Эхний хувилбар нь орон нутагт төр засгийн бодлого хэрхэн хэрэгжиж буй байдал, аймаг сумын засаг даргын хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар 19 асуулга бүхий санал асуулгыг 18 сумын 380 иргэнээс авсан. Хэрэглэгчийн үнэлгээний санал асуулгыг боловсруулахдаа иргэдэд ойлгомжтой хялбар байх үүднээс шууд үнэлгээ өгөх хувилбартай бас өөрийн санаа бодлоо үгээр бичих боломж олгосон юм.

Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг бүх сумдыг хамруулан зохион байгуулах явцдаа үзлэгийн бүрэлдэхүүнд оролцсон багийн гишүүд тухайн сумдын иргэдээс нууцлалыг ханган үнэлгээний хуудсаар иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг авч, дүнг нэгтгэн иргэдээс гаргаж буй санал дүгнэлтийг үзлэгийн нэгдсэн дүнгийн үнэлгээнд харгалзах үзүүлэлт болгон оруулж, иргэдийн бичсэн санал шүүмжлэлийг бүгдэд уншин танилцуулж байсан нь олон түмний бодол байр суурийг сумдын удирдлага, үйлчилгээний байгууллагынхан ойлгож авсанаараа чухал ач холбогдолтой болсон.

Хэрэглэгчийн үнэлгээний 1-р хувилбар: сумдаас авсан санал асуулгын хуудас

//Төр засгийн бодлого үйл ажиллагааны талаар таны бодитой үнэн зөв үнэлгээ нь төрийн байгууллагын ажлын бүтээмжийг сайжруулахад чухал хувь нэмэр болно.//

1. Таны нас..... хүйс..... боловсрол.....
2. Та асуулт бүрт өөрийн үнэлгээг “+” тэмдэгээр р өгнө үү. Үнэлгээ нь: **1- муу, 2- хангалтгүй, 3- дунд зэрэг, 4- сайн, 5- маш сайн** гэсэн дүнг илэрхийлнэ.

	Асуулгын агуулга	Үнэлгээ				
		1	2	3	4	5
1	Танай суманд өрийн хууль тогтоомж, шийдвэр хэрхэн хэрэгжиж байна вэ?					
2	Засгийн газраас иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, орлогыг нэмэгдүүлэх талаар баримталж буй бодлогын хэрэгжилт ямар байна вэ?		<input type="checkbox"/>			
3	Төрөөс үзүүлж буй тэтгэмж, хөнгөлөлтийн үр нөлөө таны амьдралд ямар нэмэр болдог вэ?					
4	ЖДҮ хөгжүүлэх ажил орон нутагт ямар үр дүнтэй явагдаж байна гэж та үздэг вэ?					
5	Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл хэр зэрэг өсч байгаа вэ?					
6	Аймгийн Засаг даргын хөтөлбөрт тусгасан зорилтууд танай суманд хэрхэн хэрэгжиж байна вэ?					
7	Сумын Засаг даргын хөтөлбөрийг хэрхэн хэрэгжиж байна гэж та үнэлэх вэ?					
8	Сумын ЗДТГ-ын ажилтнууд иргэдэд өмгөнгөн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх үүргээ хэр биелүүлж байна вэ?					
9	Танай сумын удирдлага иргэдийнхээ саналыг хэрхэн шийдвэрлэдэг вэ?					
10	Сургуулийн сургалтын чанар үйл ажиллагааны талаар ямар байр суурьтай байна вэ?					
11	Хүүхдэд олгодог “Үдийн цай”-ны чанар хүртээмж, нэр төрөл ямар байдаг вэ?					
12	Эрүүл мэндийн үйлчилгээний талаар та ямар сэтгэгдэлтэй явдаг вэ?					
13	Сумын эмнэлгийн эмч, ажилтнуудын мэдлэг чадвар, хариуцлагыг хэрхэн дүгнэх вэ?					

14	Танай суманд нийгмийн халамжийн үйлчилгээ эзнээ олж хүрдэг үү?					
15	Цагдаагийн ажилтнуудын үйл ажиллагаанд та ямар үнэлгээ өгөх вэ?					
16	Байгаль хамгаалах ажил хэрхэн явагдаж байна вэ?					
17	Газар эзэмцүүлэх, өмчлүүлэх, газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах талаар танай суманд хийгдэж буй ажлыг та юу үнэлж байна вэ?					
18	Та өөрийн Багийн Засаг даргын үйл ажиллагаанд ямар үнэлгээ өгөх вэ?					
19	Та өөрийн Багийн Засаг даргын үйл ажиллагаанд ямар үнэлгээ өгөх вэ?					

Та төрийн байгууллагуудын ажил үйлчилгээний талаар саналаа энд бичнэ үү?
гэсэн санал асуулгыг аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний тасгаас боловсруулж иргэдээс авсан.

Сумдын үйл ажиллагаанд ХШҮ хийсэн багийн үнэлгээг, орон нутгийн иргэдийн өгсөн үнэлгээтэй харьцуулбал:



	Сумын нэр	ХШҮ-ний багийн үнэлгээ		Иргэдийн үнэлгээ	оноо
		оноо	дүн		
1	Их тамир	79,4	хангалттай	Үнэлгээ хийгээгүй	
2	Чулуут	64	дутагдалтай	2,0	40
3	Хангай	74	хангалттай	4,0	80
4	Тариат	76	хангалттай	3,5	70
5	Өндөр-улаан	80	сайн	3,2	64
6	Эрдэнэмандал	85	Сайн	3,2	64
7	Жаргалант	80	Сайн	3,8	76
8	Цэцэрлэг	80	Сайн	4,2	84
9	Хайрхан	80	Сайн	3,8	76
10	Батцэнгэл	80	Сайн	4,0	80
11	Өлзийт	60	дутагдалтай	3,2	64
12	Өгийнуур	72	хангалттай	3,2	64
13	Хашаат	74,6	хангалттай	3,2	64
14	Хотонт	60,9	дутагдалтай	2,6	52
15	Цэнхэр	67,5	дутагдалтай	2,7	54
16	Төвшрүүлэх	72,8	хангалттай	2,5	50
17	Булган	61	дутагдалтай	3,0	60
18	Эрдэнэбулган	71,9	хангалттай	2,7	54
19	Цахир	72	хангалттай	3,0	60
					64



2 дугаар хувилбар: Төрийн байгууллагуудын ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн талаар хэрэглэгчийн үнэлгээ

	Үнэлгээний асуулгын агуулга	Байгууллагын үндсэн үйл ажиллагааг хэрхэн үнэлж байна вэ?	Төрийн хууль, шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлж байна вэ?	Иргэдэд хэр шуурхай үйлчилдэг вэ?	Мэдээлэл ил тод байдал хэр хангагдсан бэ?	Ажилтнуудын ур чадвар, ажил хэрэгч байдлын үнэлгээ	Дундаж үнэлгээ	оноо
1	Эрүүл мэндийн газар	4,2	3,6	3,2	3,5	3,3	3,5	70

2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс	4,0	3,3	3,0	2,6	3,2	3,2	64
3	Нийгмийн даатгалын хэлтэс	4,5	3,6	3,5	3,4	3,5	3,7	74
4	Боловсрол соёлын газар	4,2	3,3	3,0	3,0	3,1	3,3	66
5	Биеийн тамир спортын газар	4,1	3,2	3,0	3,2	3,1	3,3	66
6	Хөгжимт драмын театр	3,0	2,4	2,6	2,3	2,4	2,6	52
7	Мэргэжлийн хяналтын газар	4,1	3,2	3,4	3,5	3,4	3,6	70
8	Онцгой байдлын хэлтэс	4,2	3,5	3,6	3,3	3,6	3,7	74
9	Стандарт хэмжил зүйн хэлтэс	3,1	3,0	3,1	3,1	3,1	3,1	62
10	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба	3,0	3,2	2,3	2,5	2,8	2,8	58
11	Цагдаагийн хэлтэс	3,1	3,1	2,8	2,7	2,8	2,9	58
12	Статистикийн хэлтэс	4,1	3,4	3,4	3,3	3,5	3,4	68
13	Хөдөө аж ахуй жижиг дунд үйлдвэрийн газар	3,4	3,2	3,0	2,9	3,1	3,2	64
14	Байгаль орчин аялал жуулчлалын газар	3,2	3,1	3,0	2,9	3,0	3,1	62
15	Газрын харилцаа хот байгуулалтын газар	4,1	3,6	3,3	3,7	3,5	3,7	74
16	Хүүхдийн төлөө хэлтэс	3,5	3,4	3,4	3,2	3,4	3,4	68
17	Ус цаг уур орчны шинжилгээний төв	3,4	3,5	3,3	3,3	3,5	3,4	68
18	Татварын хэлтэс	4,1	3,5	3,3	3,3	3,4	3,5	70
19	Тээвэр авто замын газар	3,1	3,3	3,1	2,8	3,1	3,1	62
20	Улсын бүртгэлийн хэлтэс	3,2	3,1	2,9	2,9	3,2	3,1	62
21	Шүүхийн шинжилгээний алба	3,2	3,5	3,1	2,7	3,2	3,2	64

Гуравдугаар хувилбар: ИНБ-ын судалгаа

Орон нутгийн өр, захиргааны байгууллагаас гарч байгаа тогтоол шийдвэр иргэдэд хэрхэн хүрч байгаа талаар Иргэний нийгмийн байгууллагуудаас 7 асуулга бүхий санал асуулгыг 124 иргэнээс авч үндэст гаргасан.

Орон нутгийн өр, захиргааны байгууллагаас гарч байгаа тогтоол шийдвэртэй дор нь танилцах боломж олддог уу гэсэн асуулгад 17 хүн хүссэн үедээ танилцах боломжтой гэсэн бол 38 иргэн үзэж танилцах боломж олддоггүй, 62 иргэн ямар ч байсан хүн бүхэнд ил тод байдаггүй, 7 хүн нууцалдаг юм бишүү гэж хаариулжээ. Мэдээллийн ил тод байдал хангагдаагүй, гарсан шийдвэрээ сурталчилдаггүй, иргэдэд амлалтаа биелүүлдэггүй, ажилгүйдэл бууруулах дорвитой арга хэмжээ авдаггүй, хог бохирдол ихтэй байгааг иргэд шүүмжилсэн байна.

Хэрэглэгчийн үнэлгээний нийлбэр дундаж нь сумдад 3,2, аймгийн төвд 3,3 буюу

дунд зэрэг гэсэн үнэлгээг өгчээ.

/ Цаашид иргэдийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх шаардлагатай юм/

Аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний тасаг